

ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Дархан Уул аймаг, Дархан сум 2025 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан	11
4.1. Ерөнхий зүйл.....	11
4.2. Материаллаг байдал	12
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. Аудитын илрүүлэлт	13
Залруулга.....	13
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 155

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь тайлант онд 842,522.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,123,198.1 мянган төгрөгийн зардал гарган, 280,675.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн

4525020239

үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөж, 98.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,533,059.68	608,928.95
1.1.2	Дансны авлага	0.00	0.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	14,109,739.20	17,644,967.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	14,099,635.00	42,015,171.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	29,742,433.88	60,269,067.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,392,663,131.11	3,159,946,617.67
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	0.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,392,663,131.11	3,159,946,617.67
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,422,405,564.99	3,220,215,685.14
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	0.00	0.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	182,151.00
2.1.1.3	Татварын өр	5,903,740.78	0.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,943,923.56	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	100,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,847,664.34	282,151.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,847,664.34	282,151.00
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	111,595,600.00	111,595,600.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,349,166,957.59	1,349,166,957.59
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,384,909,613.00	2,472,960,883.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(433,114,269.94)	(713,789,906.45)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,412,557,900.65	3,219,933,534.14
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,422,405,564.99	3,220,215,685.14

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	290,643,266.71	598,596,545.86
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	290,643,266.71	598,596,545.86
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	186,395,200.00	243,926,000.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	625,870,437.23	1,030,258,367.58
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(148,831,970.52)	(187,735,821.72)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(148,831,970.52)	(187,735,821.72)
21	Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)	0.00	(92,939,814.79)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(148,831,970.52)	(280,675,636.51)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	477,038,466.71	842,522,545.86
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,384,909,613.00	(284,282,299.42)	2,241,148,791.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,384,909,613.00	(284,282,299.42)	2,241,148,791.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(148,831,970.53)	(148,831,970.53)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-

7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,384,909,613.00	(433,114,269.94)	2,412,557,900.65
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	1,384,909,613.00	(433,114,269.94)	2,412,557,900.65
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(280,675,636.51)	(280,675,636.51)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт			1,088,051,270.00		1,088,051,270.00
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,472,960,883.00	(213,789,906.45)	3,249,933,534.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	467,249,715.51	842,418,550.06
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	280,854,515.51	598,492,550.06
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	186,395,200.00	243,926,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	451,621,697.38	817,559,680.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	195,780,992.44	367,664,924.09
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	29,607,544.26	48,957,690.10
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,120,425.00	68,726,270.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	119,085,170.68	72,044,634.60
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,056,820.97	193,659,140.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	751,175.00	442,500.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	350,370.00	514,380.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	71,869,199.03	65,550,142.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,628,018.13	24,858,869.27
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00

2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,248,000.00	25,783,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,248,000.00	25,783,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,248,000.00)	(25,783,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,380,018.13	(924,130.73)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,041.55	1,533,059.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,533,059.68	608,928.95



2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	477,038,466.70	654,986,194.80	842,522,545.86	187,536,351.06	128.63
	Үүнээс: Цэвэр борлуулалт	290,643,266.70	450,921,394.80	598,596,545.86	147,675,151.06	132.75
	Бусад орлого	186,395,200.00	204,064,800.00	243,926,000.00	39,861,200.00	0.00
3	Нийт зардал	625,870,437.23	654,986,194.80	1,123,198,182.34	468,211,198.57	157.29
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	0.00
	б) Ерөнхий удирдлагын зардал	625,870,437.23	654,986,194.80	1,030,258,367.68	875,272,172.78	157.29
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	0.00	0.00	92,939,814.79	92,939,814.79	0.00
4	Цэвэр ашиг, алдагдал	(148,831,970.53)	0.00	(280,675,636.51)	(280,675,636.51)	0.00



3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь "Байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл, аюулгүй, таатай

орчин бүрдүүлэх замаар иргэдийн нийтлэг эрх ашгийг хангах" гэсэн эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Аж ахуйн нэгж болон айл өрхийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах,
- Аж ахуйн нэгжийг дулаан эрчим хүчээр хангах,
- Нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх,
- Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд автобусны үйлчилгээ үзүүлэх,
- Хог хаягдлыг цэвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол;

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын мөрдөж буй "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 797,810.1 мянган төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	1,533.1	608.9	(924.1)
Авлага	14,109.7	17,645.0	3,535.2
Урьдчилгаа тооцоо	0.0	0.0	0.0
Бараа материал	14,099.6	42,015.2	27,915.5
Үндсэн хөрөнгө	2,392,663.1	3,159,946.6	767,283.5
Нийт хөрөнгө	2,422,405.6	3,220,215.7	797,810.1
Өр төлбөр	9,847.7	282.2	(9,565.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,412,557.9	3,219,933.5	807,375.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,422,405.6	3,220,215.7	797,810.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 608.9 мянган төгрөг болж 924.1 мянган төгрөгөөр буурсан нь 842,418.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 843,342.7 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 17,645.0 мянган төгрөг болж 3,535.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны түлш халаалт, цэвэр бохир усны авлага 16,724.3 мянган төгрөг, байрны түрээсийн авлага 233.0 мянган төгрөг, бусад тооцооны авлага 687.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,015.2 мянган төгрөг болж 27,915.5 мянган төгрөгөөр өссөн нь 254,915.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 226,999.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 767,283.5 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 7,883.0 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, 15,100.0 мянган төгрөгийн HP25Ж маркын уурын зуух, 2,800.0 мянган төгрөгийн чиргүүлтэй мотоциклыг тус тус худалдан авсан, Дархан-Уул аймгийн Орхон сумын ИТХ-ын 2024 оны 05 тоот тогтоолоор 169,900.0 мянган төгрөгийн өөрөө буулгагч авто машин, 176,000.0 мянган төгрөгийн экскаватор, 248,204.7 мянган төгрөгийн гэр хорооллын цамхагт гэрэлтүүлэг, 87,300.0 мянган төгрөгийн галын тусгай зориулалтын гараж, 9,945.0 мянган төгрөгийн 90 ширхэг бут мод, 10,000.0 мянган төгрөгийн мод хамгаалах хашааг тус тус шинээр хүлээн авсан, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 сарын 02 өдрийн А/34 тоот тушаалаар Орхон сумын эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 65,000.0 мянган төгрөгийн усны халаалтын зуух, 2024 оны 06 сарын 20 өдрийн А/18 тоот тушаалаар Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төвөөс 245,437.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй лууван хураагч

тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан, мөн Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 сарын 20 өдрийн А/16 тоот тушаалаар 1,064.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2024 оны 12 сарын 02 өдрийн А/35 тоот тушаалаар 24,000.0 мянган төгрөгийн автобус, 35,200.0 мянган төгрөгийн цэвэрлэх байгууламжийн барилга, 16,000.0 мянган төгрөгийн компьютер экскаваторыг тус тус ашиглах хугацааг сунган, үнийг шинэчлэн тогтоож орлого авсан байна. Орхон сумын Засаг даргын тамгын газарт 110,000.0 мянган төгрөгийн наадмын талбайг шилжүүлэн өгсөн, Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчидийн хурлын 2024 оны 7 сарын 31 өдрийн 29 дүгээр тогтоолоор 119,141.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийг актлан данс бүртгэлээс хасч, тайлант онд 253,611.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 282.2 мянган төгрөг болж буурсан нь 2023 онд үүссэн байгууллага болон хувь хүмүүст төлөх өглөгийг төлж дууссантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 807,375.6 мянган төгрөг болж өссөн нь тухайн онд хийгдсэн хөрөнгө оруулалт, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Орхон сумын Засаг даргаар батлуулсан байна.

Тайлант онд нийт орлогыг 654,986.2 мянган төгрөгөөр, нийт үйл ажиллагааны зардлыг 654,986.2 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 243,926.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 598,492.5 мянган төгрөг, нийт 842,418.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 843,342.7 мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна.

Тайлант онд 280,675.6 мянган төгрөг алдагдалтай ажилласан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлыг харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд байгууллагын татварын тодорхойлолтоор татварын төрөл бүрээр илүү төлөлттэй байгааг хянаж татварын байгууллагатай тооцоо хийж үлдэгдлийг залруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

"Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг "Пийк Ом Аудит" ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлын дүн 654,986.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13,099.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 49,362.4 мянган төгрөгийн 8 гүйлгээ, 6.4.8 -д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ,

төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 30,955.3 мянган төгрөгийн 16 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,780.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 43,798.5 мянган төгрөгийн албан 3 шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	1,780.4	2	1,780.4	100.0
Албан шаардлага	3	43,798.5	3	43,798.5	100.0
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	5	45,578.9	5	45,578.9	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитын явцад дараах алдаануудыг залруулсан. Үүнд:

- Нэг удаагийн шагнал урамшууллаас суутгасан 100.0 мянган төгрөгийн ХХОАТ өглөгөөр тусгаагүй,
- Бараа материалын тайланд 4,768.7 мянган төгрөгийн 54.19 тн нүүрсийг данс буруу бүртгэсэн, 10,424.5 мянган төгрөгийн 118.46 тн нүүрсийг 12 сард зарцуулснаар тайлагнасан,

- Орхон сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсэн өгсөн 110,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүтгэлээс хасаагүй,
- Ашиглах жил оруулаагүйгээс 1,213.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцсон,

Санхүүгийн тайланг нийт 126,506.4 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 12, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", "Иж бүрэн байх", "Толилуулга", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар нийт 3,275.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 195.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,080.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгөөр 195.0 мянган төгрөгийн согтууруулах төрлийн ундаа худалдан авч ажилтан албан хаагч нарт бэлгэнд өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно", Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "... улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалын тайлан, орлого зарлагыг түүвэрлэн шалгахад бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн, үндсэн хөрөнгийн шинж чанартай 3,080.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", гэж заасныг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Бараа материалыг зөв ангилан бүртгэх, хөрөнгийг холбогдох хууль, заавар, журмын дагуу бүртгэж байх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Нэг удаагийн шагнал урамшууллаас суутгасан ХХОАТ өглөгөөр тусгаагүй.	1	100.0	1	100.0			1	100.0				
Бараа материалын тайланд 54.19 тн нүүрсийг данс буруу бүртгэсэн, 118.46 тн нүүрсийг 12 сард зарцуулснаар тайлагнасан	1	15,193.2			1	15,193.2	1	15,193.2				
Шилжүүлсэн хөрөнгийг зарлагын гүйлгээ хийгээгүй	1	110,000.0	1	110,000.0			1	110,000.0				
Ашиглах жил оруулаагүйгээс үндсэн хөрөнгийн элдэгдэл дутуу бодуулсан.	1	1,213.2			1	1,213.2	1	1,213.2				
Дүн	4	126,506.4	2	110,100.0	2	16,406.4	4	126,506.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр согтууруулах төрлийн ундаа худалдан авч ажилтан албан хаагч нарт бэлгэнд өгсөн.	1	195.0	1	195.0								
Бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг ангилан холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх.	1	3,080.0					1	3,080.0				
Дүн	2	3,275.0	1	195.0			1	3,080.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга				Нийт зөрчил		Үүнээс						/мянган төгрөгөөр/	
						Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
6.4.4-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 49,362.4 мянган төгрөгийн 8 гүйлгээ, 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 30,955.3 мянган төгрөгийн 16 шийдвэрийг мэдээлээгүй байна.				1	80,317.7					1	80,317.7		
Дүн				1	80,317.7					1	80,317.7		
Нийт дүн				1	80,317.7	0.0	0.0			1	80,317.7		

/мянган төгрөгөөр/



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 03 сар 14 өдөр

Дугаар 09/92-24010611-8АА-2025/МА/СТА-02А Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээлэл бүрэн оруулах зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс, шилэн дансны дахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 80,317,700.00 төгрөгийн 24 мэдээлэлийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга Б.Хишигбуян, нягтлан бодогч Н.Цэрэнханд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,

ТЭГТҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.БАТБОЛД

4525040255



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01/79-24010611-888-2025/41/1А-177- Дархан сум
06А.

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Орхон сумын "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тайлант онд 195,000.00 төгрөгийн согтууруулах төрлийн ундаа худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно", Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь "... улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн " гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 195,000.00 /нэг зуун ерэн таван мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Орхон тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга Б.Буянхишиг, нягтлан бодогч Н.Цэрэнханд нарт хариуцуулав.

4525050224

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.БАТБОЛД